



БАТЛАВ
ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Н.ХОНГОРЗУЛ

ДОРНОГОВЬ АЙМАГ, САЙНШАНД СУМ, 2-Р БАГ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ-1 ГУДАМЖ 100,
102-Р БАЙРНЫ НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ТАЛБАЙД АВТО МАШИНЫ ЗОГСООЛ
БАЙГУУЛАХ АЖИЛ

2024 оны 03 дугаар сарын 28-ны өдөр

Сайншанд сум

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Дорноговь аймаг, Сайншанд сум, 2-р баг, Эрх чөлөөний-1 гудамж 100, 102-р байрны нийтийн эзэмшлийн талбайд авто машины зогсоол байгуулах ажлыг гүйцэтгэхдээ холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, нормын дагуу хийх ба дараах шаардлагуудыг бүрэн хангасан байна.

1. Ажил гүйцэтгэх хугацааны график (хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчний тоо)-ийг тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачлал, техникийн тодорхойлолтыг боловсруулж ирүүлнэ.
2. Зам, замын байгууламжийн ажлыг зам, замын байгууламжийн норм ба дүрэм /БНБД/, стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэх.
3. Талбайн зохион байгуулалтын зураг, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах төслийн баримт бичгийг тухайн ажилд нийцүүлэн боловсруулах.
4. Ажлыг техникийн ерөнхий шаардлагын дагуу дулааны улиралд гүйцэтгэнэ.

Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:

1. Авто зам барих, Засварлах, Барилга угсралтын тусгай зөвшөөрөлтэй байх.
2. Зам, замын байгууламжийн барилга угсралт, засвар арчлалтыг ажлын тоо хэмжээний дагуу чанарын өндөр төвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.
3. Гэрээнд тусгагдсан ажил бүрийг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, БНБД, стандартын дагуу гүйцэтгэнэ.
4. Авто замын барилга угсралтын ажлыг авто зам барих ажлын технологийн дарааллын дагуу гүйцэтгэнэ.
5. Үндэсний үйлдвэрийн материал сонгон авбал бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргана.
Импортын материал сонгон худалдан авах тохиолдолд тохирлын гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргана.
6. Зам, замын байгууламжийн ажлыг эхлүүлэхдээ иргэдийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор анхааруулах тэмдэг, самбар байршуулах, хашаа барих зэрэг шаардлагатай арга хэмжээг авч гэнэтийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллана.

7. Барилга угсралтын талбайд ажлын журнал, батлагдсан зураг төсөл, хэрэглэгдэж буй материалын лабораторийн сорилтын дүн, тохирлын гэрчилгээ, гарал үүслийн бичиг баримтуудыг бэлэн байлгах.

8. Дүүргэгч материалын шинжилгээг итгэмжлэгдсэн лаборатори, болон талбайн туршилт шинжилгээг техникийн шаардлагын дагуу хийж ил далд ажлын актад хавсаргах.

9. Гүйцэтгэсэн ажлыг ил, далд ажлын акт, схем зураг, фото зургаар баталгаажуулсан байна.

10. Гүйцэтгэгч нь барилгын ажлыг ил, далд ажлын актыг баталгаажуулах, үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл хөтлөх, салбарын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий захиалагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг бүрэн биелүүлнэ.

11. Энэхүү техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, салбарын хяналтын улсын байцаагч өөрийн эрхийн дагуу барилгын ажилд хугацаатай албан даалгавар өгөх, торгууль тавих, тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй.

Тендерийн материалд тавигдах шаардлага:

1. Төсвийн тооцоог "Авто замын барилгын ажлын жишиг норм" БНБД 81-25-07, Авто зам, замын байгууламжийн засварын ажлын төсвийн жишиг норм БНБД 81-26-08 суурь нормууд болон Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 07 дугаар сарын 31-ны өдрийн 256 дугаар тушаалаар батлагдсан "Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм" ЗЗБНБД 81-013-2019-ыг ашиглан хийж гүйцэтгэнэ.

2. Ажилчдын тарифт цалинг "Зам, тээврийн хөгжлийн сайд"-ын 2019 оны 256 дугаар тушаалаар батлагдсаны дагуу ажилчдын үндсэн цалин, нэмэгдэл цалин, тээврийн жолоочийн цалин, машин механизмын операторчдын цалин, нүүлгэн шилжүүлэх ажлын цалингийн нийлбэрээс 15.1%-иар бодож төсөвт тусгах, Авто тээврийн зардлыг "Замын машин механизмын ашиглалтын цагийн жишиг үнэ"-ийн дагуу тус тус тооцно.

3. Монгол улсын Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дүгээр зүйлд заасны дагуу ажил олгогч (компани)-ийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг зам барилгын ажилчдын цалин, нэмэгдэл цалин, талбайн инженер, техникийн ажилтнуудын цалингийн нийлбэр буюу нийт цалингийн сангийн 11.7%-иар Засгийн газрын 2008 оны 142 дугаар тогтоолын дагуу "Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал"-ын шимтгэлийн хувь хэмжээг 2.8%-иар нийт 14.5%-иар тооцно.

4. ЗТАЖ-ын сайдын 2007 оны 187 дугаар тушаалын дагуу удирдлагын зардлыг нийт цалингийн сангийн 63.5%-иар, ашгийн хэмжээг цалингийн сангийн 71.8%-иар тооцно

5. Захиалагчийн хяналтын зардлыг төсвийн 2%, магадалшгүй ажлын зардлыг шууд зардлын дүнгээс 2%, нэмэгдсэн өртгийн албан татварыг "Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай" Монгол улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалтын дагуу барилга угсралтын ажлын зардлын дүнгээс 10%-иар тооцно.

6. ХАБЭА-н үйл ажиллагааны зардлыг шууд зардлын дүнгээс 2.5%-иар тооцно, энэ зардал нь "Авто замын салбарын үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгааллын иж бүрэн дүрэм"-ийн дагуу замын барилгын ажлын туршид хийгдэх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааны зардал юм.

7. Норм, нормативын санг 0.4%-иар тооцно.

8. Үнийн тарифыг ажилбар тус бүрээр тооцож ирүүлнэ.

9. Авто зам, замын байгууламжийн барилга угсралтын ажлын мэргэшсэн инженертэй байх.

Ажлын тоо хэмжээ

Д/д	Ажилбарын нэр	Хэмжих нэгж	Тоо
01. Бетон зогсоолын ажил			
1	Замын цэвэрлэлтийг таслагдвал хийх	Гкм	0.59
2	Механизмаар өнгөрөх эхний шороог ухааж овоолох	м3	136.50
3	Зогсоол хийх талбайг бүдсэлдсээр түрж тэгшлэх	м2	3,519.31
4	Шороог гараар гарааж тэгшлэх	м3	137.90
5	Суурийн доод үе байгуулж нягтруулалт хийх	100м3	10.56
6	Бүтэцтэй чулуун суурь байгуулах б=150мм	100м3	4.03
7	Зохист бүрэлдэхүүнтэй элс-хайрган хольцоор хучилт байгуулах б=100мм	100м3	2.68
8	Цемент бетон хольцоор зам талбайг гараар хийх б=150мм. БМ250	100м3	4.03
9	Авто замын ханлага суурцуулах	100у/м	6.55
10	Нэмэгдэх шороог экскаватороор автосамосвалд ашиж зөөж авчрах	м3	136.50
11	Шугам сүлжээтэй хэсэгт даанцай хавтан угсрах	100м2	11.15
02. Явган замын ажил			
12	Явган хүний замын суурийг элс-хайрган хольцоор хийх	100м3	0.84
13	Явган хүний замын ханлага тавих	100м	5.28
14	Явган хүний замын хучилтыг өнгөт хавтангаар угсрах	100м2	8.35
15	Бетон хаявч цутгах БМ100	м3	45.50
03. Буулгах ажил			
16	Хуучин мууссан бетон зам талбайг ханлага бетоны хамт хийн алхаар ухааж задгаж буулгах	м2	1,071.00
17	Хаяглал хавтан ховхолж авах	ш	0.00
18	Авто замын өлдсөн, хуучин ханлагыг задгаж буулгах	1 у/м	420.00
99.Хөг хаягдлын дүн			
19	Хөг хаягдал	ш	0.00

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ ХЯНАСАН:

АЗДТГ-ЫН ХБТХОХ-ИЙН ДАРГА



/Ц.МӨНХЭРДЭНЭ/

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОВСРУУЛСАН:

АЗДТГ-ЫН ХБТХОХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН:



/Н.БЯМБАЦЭЦЭГ/

